



ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2023 оны 11 дугаар сарын 08

Дугаар 13/06

Баян-Өндөр сум

Дүгнэлт өгөх, төлөвлөгөө  
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.19 дэх заалт, 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1 дахь заалт, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.1.2, 17.1.5 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 206 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Аймгийн хэмжээнд 2023 онд ой, хээрийн түймэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар хийсэн ажлыг “Бүрэн хэрэгжсэн” гэж дүгнэсүгэй.

2.Аймгийн хэмжээнд 2024 онд ой, хээрийн түймэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3.Аймгийн хэмжээнд 2024 онд ой хээрийн түймэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хамгаалах, бэлтгэл, бэлэн байдлыг хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга (С.Батжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Д. МӨНХБАТ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн Ээлжит бус XIII хуралдааны 13-р дугаар тогтоолын хавсралт

ОРХОН АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2024 ОНД ОЙ, ХЭЭРИЙН ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ХАМГААЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийж гүйцэтгэх ажил	Хугацаа	Хамтран ажиллах байгууллага	Хүрэх үр дүн
<b>1. Орон нутагт хэрэгжүүлэх бодлого хөтөлбөрийн хүрээнд.</b>				
1.1	Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлын тайлан мэдээг нэгтгэн аймгийн ИТХ-д танилцуулах	2023 оны 12 дугаар сард		Жил бүр ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажлын үр дүнг тооцох, мэргэжлийн байгууллагуудын уялдаа холбоог нэмэгдүүлэх
1.2	Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2024 онд хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан аймгийн ИТХ-д санал оруулах, батлуулах	2023 оны 12 дугаар сард	Аймгийн БОАЖГ, ОБГ	Үйл ажиллагааны гүйцэтгэл тодорхой болно.
1.3	Төлөвлөгөөний дагуу аймгийн ИТХ-ын тогтоол, аймгийн Засаг даргын захирамж гаргуулан мэргэжлийн байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтийг хангуулах	2024 оны 01 дүгээр сард		Баян-Өндөр, Жаргалант сумдын Засаг даргын захирамж гаргуулан хариуцлагатай эргүүл хяналт шалгалт хийх хуваарь гарган зохион байгуулна.
1.4	Баян-Өндөр, Жаргалант сумдын ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр гаргасан төлөвлөгөөнд тодотгол хийх	2024 оны 02 дугаар сард		Ой хээрийн түймэртэй тэмцэх, ажиллах бүрэлдэхүүнийг томилгоожуулснаар үйл ажиллагааны гүйцэтгэл тодорхой болно.
1.5	ой хээрийн түймрийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг холбогдох байгууллагуудтай хамтран хийх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж боловсруулах	II, III улиралд	Аймгийн БОАЖГ, ОБГ УЦУОШТ	Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодотгон зохион байгуулах

2.Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны чиглэлээр:				
2.1	Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлийн мэргэжлийн байгууллагуудтай хамтран радио, телевизийн нэвтрүүлэг шторк бэлтгэж иргэд олон нийтэд мэдээлэл өгөх.	II, III, IV улиралд	Аймгийн БОАЖГ Баян-Өндөр, Жаргалант сум	Хавар, намар хуурайшилтын улиралд өдөр бүр 4-6 удаагийн давтамжтайгаар (нийт 160 хоног)
2.2	Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр гарын авлага, тараах материал шинэчлэн боловсруулж иргэд, олон нийтэд танилцуулах, тараах	II, IV улиралд		2-4 төрлийн гарын авлага, тараах материал
2.3	Ой мод руу орох гол зам, зорчих газар харагдахуйц өндөрлөг газарт гал түймрээс урьдчилан сэргийлэх самбар байрлуулах, одоо байгаа самбар зураг тэмдэглэгээг сэргээх.	II улиралд	Сумдын ЗДТГ	Анхааруулга, сээрэмжлүүлгийн хүртээмж нэмэгдэх
2.4	Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, түймэртэй тэмцэх анхан шатны мэдлэг олгох сургалтыг ойн нөхөрлөл рүү болон сайн дурын идэвхтэн бүлгүүдэд зохион байгуулах.	II, III улиралд	Аймгийн ОБГ, БОАЖГ, Сумдын ЗДТГ	Ойн нөхөрлөл рүү болон сайн дурын идэвхтнүүд ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний талаар мэдлэг авсан байх
2.5	Зуны хэт халалтын улмаас ой, хээрийн түймрийн аюулын зэрэглэл нэн аюултай, аюултай түвшинд хүрсэн үед хөдөлгөөнт анхааруулга сурталчилгааны ажил зохион байгуулах.	III улиралд	Аймгийн БОАЖГ, ААНБ-ууд	Аймгийн УЦУОШГ-аас гаргасан түймрийн аюулын зэргийг үндэслэнэ
3.Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ойн аж ахуйн арга хэмжээний чиглэлээр:				
3.1.	Хуурайшилтын улиралд цаг уурын мэдээлэл нэгтгэж, түймрийн аюулын зэрэглэл тогтоох, холбогдох байгууллагыг шуурхай мэдээллээр хангах.	Түймрийн аюултай үед	Аймгийн ОБГ УЦУОШГ	Багц мессэж, үрэн телефон утасны нэгж байнгын бэлэн байдалд ажиллуулах

3.2.	Цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалж, түймрийн аюулын дэглэм тогтоох	Түймрийн нэн аюултай үед	Сумдын ЗДТГ	Түймэр гарахаас урьдчилан сэргийлж, аюулгүй байдлыг хангуулна. Мэргэжлийн ангийн бэлтгэл бэлэн байдлыг хангуулах
3.3.	Сумдын ЗДТГ болон ойн нөхөрлөл аж ахуй нэгж, байгууллагуудын түймэртэй тэмцэх бэлтгэл бэлэн байдлыг шалгах, түймэртэй тэмцэх багаж хэрэгслийн нөөц бүрдүүлэх.	II, III улиралд	Аймгийн ОБГ, БОАЖГ, Сумдын ЗДТГ	Баян-Өндөр, Жаргалант сумын ЗДТГ, ойн нөхөрлөлийн гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн нөөц, бэлтгэл бэлэн байдлыг хангагдана
3.4.	Ой хээрийн түймрийн аюултай болон нэн аюултай үед ойгоос мод бэлтгэх үйл ажиллагааг хязгаарлах.	Түймрийн аюултай үед	Сумдын ЗДТГ	Аймгийн УЦУОШГ-аас гаргасан түймрийн аюулын зэргийг үндэслэнэ.
<b>4. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх эргүүл, шалгалт ажлын чиглэлээр:</b>				
4.1.	Түймрийн аюултай үед сургууль төгсөгчдийн баяр, хавар, намрын аялал зугаалгын үеэр ойн бүсэд зорчихыг хязгаарлах аймгийн Засаг даргын захирамж гаргуулах, эргүүл шалгалт хийх, иргэдэд анхааруулга санамж өгөх	5, 6 сард	Аймгийн БОАЖГ ОБГ	Ой, хээрийн түймэр гарахаас урьдчилан сэргийлж, гарсан тохиолдолд хохирол багатай даван туулахад оршино.
4.2.	Орхон аймгийн нутаг дэвсгэрийн ойролцоох амралт, сувиллын үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуй нэгжүүдийн ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангасан байдалд тогтмол хяналт шалгалт зохион байгуулах.	II, III улиралд		
4.3.	Ой, хээрийн түймрийн аюултай үед хөрш зэргэлдээ аймгуудын сумдтай хамтран эргүүл шалгалтыг зохион байгуулах.	Түймрийн аюулын зэрэглэл нэн аюултай, аюултай түвшинд хүрсэн үед	Аймгийн БОАЖГ, ОБГ, сумын ЗДТГ	Хамтын ажиллагаа өргөжиж, урьдчилан сэргийлэх ажил сайжирна.
4.4.	Хуурайшилтын улиралд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх нэгдсэн аяныг төрийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулах.			Ой хээрийн түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх ажил эрчимжиж, иргэдэд мэдээлэл хүрнэ

4.5.	Ойн санг гэрээгээр нөхөрлөлүүдийн төлөвлөгөөний урьдчилан чиглэлээр зэрэгжүүлсэн ажлын биелэлт, бэлэн байдлыг шалгах.	Ойн менежментийн түймрээс тэмцэх түймэртэй ажлын биелэлт, бэлэн байдлыг шалгах.	II, IV улиралд	Сумдын ЗДТГ	Сумдын Засаг даргын захирамжаар аймгийн ОБГ, БОАЖГ, МХГ, СДОА зэрэг байгууллагуудын төлөөллийг оруулсан ажлын хэсэг байгуулна.
4.6.	Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн камерын хяналтад хуурайшилтын улиралд операторуудыг ажиллуулах.	Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн камерын хяналтад хуурайшилтын улиралд операторуудыг ажиллуулах.	II, III улиралд	Аймгийн ОБГ, МШУТ	Шар өвсний гал түймрийг эрт илрүүлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах
4.7.	Нисгэгчгүй нисдэг төхөөрөмж (дрон) ашиглан шар өвс болон ой хээрийн түймрээр урьдчилан сэргийлэх эргүүл хийх, гарсан гал түймрийн нөхцөл байдлыг тандаж хариу арга хэмжээг зохион байгуулах.	Нисгэгчгүй нисдэг төхөөрөмж (дрон) ашиглан шар өвс болон ой хээрийн түймрээр урьдчилан сэргийлэх эргүүл хийх, гарсан гал түймрийн нөхцөл байдлыг тандаж хариу арга хэмжээг зохион байгуулах.	II, III улиралд	Аймгийн ОБГ, БОАЖГ	Шар өвс болон ой хээрийн түймрийг эрт илрүүлэх, нөхцөл байдлыг агаараас тандан хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах
<b>Нийт 4 хэсэг 21 заалттай</b>					